

МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЭРХ БҮХИЙ
АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015.02.25

Хөвд

1. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах үйл ажиллагааны талаар

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журмын дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан хугацаанд 2014 оны 02 дугаар сард 492 мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар шивүүлж хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

2015 оны 1 дүгээр сард 264 мэдүүлэг гаргагчийн нэрсийг урьдчилсан байдлаар гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Мэдүүлэг гаргагчдаас мэдүүлгийг 2015 оны 2 дугаар сарын 15-ны дотор гаргуулан авч, тухай бүр бүртгэл хөтлөн, бүрэн гүйцэд баталгаажуулж ажиллалаа.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсны дагуу 228 төрийн албан хаагчийг ХАСХОМ гаргах жагсаалтаас хассан.

Авлигатай тэмцэх газраас үүрэг чиглэл өгсөний дагуу орон нутгийг хөгжүүлэх сангаас болон улсын төсвийн хөрөнгөөр сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан 11 төрийн бус байгууллагын тэргүүнээс хөрөнгө орлогын мэдүүлгийг авахаар байсан боловч эдгээрээс 2 албан тушаалтан нь Улаанбаатар хотоос ирж сургалт хийсэн, 2 нь аймгийн болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч учраас харьяа байгууллагадаа ХАСХОМ-ээ гаргаж өгсөн учраас 7 албан тушаалтны ХАСХОМ-ыг гаргуулан авч meduuleg.iaas.mn сайтад шивж баталгаажуулсан.

Мөн мэдүүлэг гаргагчдын мэдүүлэг бүрэн гүйцэд бөглөгдсөн эсэх, алдаа гарсан эсэхэд хяналт тавин алдаа гарсан тохиолдолд нэн даруй засуулах арга хэмжээ авч заавар, зөвлөмж өгөв.

Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан албан тушаалтны хувийн ашиг

сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл, мэдэгдэл тайлбар, тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл зэргийг хөтлөн ажиллаж байна.

2014 онд шинээр албан тушаалд томилогдсон 46 албан тушаалтны ХАСХОМ, их хэмжээний өөрчлөлт орсон 2 албан хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь гаргуулан авч программд шивж оруулсан.

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбар гаргасан 4 албан тушаалтны мэдэгдлийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн хариуг тухай бүр хүргүүлэлээ.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журмын дагуу 2 мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулбарыг гарган өгч бүртгэлжүүлээ.

2. Хяналтын үйл ажиллагааны талаар

Хууль зөрчсөн тухай Авлигатай тэмцэх газраас ирсэн дүгнэлтийн дагуу зөрчил гаргасан 6 байгууллагын даргад зохих хариуцлага тооцож хэрэгжилтэнд хяналт тавьлаа.

Төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан сумдын эрх бүхий албан тушаалтны ажлыг газар дээр шалгах боломжгүй учраас албан бичгээр ажиллах хуваарийг сум бүрт хүргүүлж хуваарийн дагуу хийсэн ажлыг шалгаж, зөвлөгөө зөвлөмж өгөв.

2015 оны 01 дүгээр сарын 06-наас эхлэн аймгийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэгт багтан "Хууль дүрэм бодит амьдралд-2" аян зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/457 дугаар захирамж, Сайн засаглалыг бэхжүүлэх тухай 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, байгууллагуудын Ёс зүйн хорооны ажил болон ХАСХОМ-ийн бүртгэлийг шалгаж заавар зөвлөмж өгсөн.

2014 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авах явцдаа сумдын Тамгын газрын дарга нар буюу эрх бүхий албан тушаалтны ажлын явц, ХАСХОМ-ын бүртгэлүүдийг хянан шалгаж заавар зөвлөгөө өглөө.

3. Зөвлөмж болон сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны талаар

Аймгийн эрх бүхий албан тушаалтны ажлын ачааллыг багасгах зорилгоор Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрыг хариуцсан эрх бүхий

албан тушаалтныг байгууллагын даргаар нь томилсон тушаал гаргуулж эрх үүсгэж программд бүртгэж нууц код олгож хариуцах ажлын талаар зааварчилгаа, зөвлөмж өгсөн.

Сумдын эрх зүйн ажил хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт семинарыг 3 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг сургалт семинараар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт Авлигын эсрэг жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтууд, ХАСХОМ бүрдүүлэлтийн ажлын тайлан болон цаашид анхаарах асуудлын талаар семинар өгч, санал солилцов.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран 2 удаа зохион байгуулж гарын авлага материал тараасан.

Мерси кор олон улсын байгууллагатай хамтран "Хууль дүрэм бодит амьдралд-2" аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж бүх сумыг хамруулан аяны хүрээнд хийх ажлын чиглэл өгч, явцыг хянаж заавар зөвлөгөө өгч ажилласан ба аяны сэдвээр илтгэлийн уралдаан зарлан шалгаруулж, аяны үр дүнгийн сургалт, хэлэлцүүлгийг бүх сумын ЗДТГ-ын дарга, эрх зүйн ажилтнуудыг оролцуулан хийж, аяны үр дүнгээр бусдаас тэргүүлсэн 5 сумын сайн туршлагыг тодруулан бусдад түгээлээ.

Мөн Мерси кор олон улсын байгууллагатай хамтран "Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох" судалгааг танилцуулах сургалтыг байгууллагын дарга, албан тушаалтнууд болон иргэдийг оролцуулсан 132 хүнийг хамруулан зохион байгуулав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засаг даргын 2014 оны 09 дүгээр албан даалгавар гарган сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллав.

Сум, байгууллагуудаас давхар ажил эрхлэлтийн болон түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа ажилтнуудын судалгааг гаргуулан авсан.

Төрийн жинхэнэ албан тушаалд томилогдохоор нэр дэвшүүлж, урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсны дараа тухайн иргэнд урьдчилсан мэдүүлгийн хариуг танилцуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 11, 12 дугаар зүйлийг мөрдөж ажиллах талаар зааварчилгаа өгч хуулийн заалтаас хувилж тараав.

Мөн төрийн байгууллагын төрийн албан хаагчдад ашиг сонирхлын зөрчилгүй гэх мэдэгдлийг тухай бүр мэдүүлж байх талаар зааварчилгаа өгч, мэдэгдлийг тараав.

2014 онд нийтийн албан тушаалд томилогдсон 46 төрийн албан хаагчийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэв.

Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан 54 тендерийн хорооны 268 дарга, гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргуулан авч шийдвэрлэн meduuleg.iaac.mn сайтад бүртгэж ажиллав.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн ашиг сонирхлын зөрчлөөс үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэсэн албан бичгийг нэр дэвшигчид тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, мөн хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж хууль тайлбарлан танилцуулах хуудаст гарын үсэг зуруулан авч, сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Байгууллагуудад зөвлөмж 1, албан бичиг 9, сумдад зөвлөмж 1, албан бичиг 18-ыг боловсруулан хүргүүлж хариуг нь авлаа.

Мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд эрх бүхий албан тушаалтны бүртгэх бүртгэлүүдийг тогтмол хөтлөж байна.

Нийгмийн даатгалын хэлтэс, Аудитын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс зэрэг байгууллагуудын ЭБАТ-ын үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

4. Бусад хийсэн ажлын талаар

2014 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг шивэх явцад сумдын эрх бүхий албан тушаалтнуудын ажлын хариуцлагаас шалтгаалсан бэрхшээл гарч байсан боловч шуурхай арга хэмжээ авч Авлигатай тэмцэх газрын мэргэжилтнүүдтэй хамтарч ажилласны үр дүнд мэдүүлгээ хугацаанд нь зөрчилгүй гаргаж дууслаа.

Мэдүүлэг гаргуулах үед нууц үг тухайн хүний цахим хаягт ирэхгүй байх, ХАСХОМ-ээ хэвлэж болохгүй байх, шивж оруулсан албан тушаалтны ХАСХОМ тайланд тусгагдаагүй идэвхигүй болсон зэрэг цахим сүлжээний алдаанаас бэрхшээл үүсэж байсан.

Мөн 2012, 2013 оны ХАСХОМ өгч байсан email хаяг нь болохгүй байгаа, нууц үгээ мартсан гэсэн албан тушаалтнууд ирж ажлын ачааллыг нэмэгдүүлж байлаа.

Иймд email хаяг нь болохгүй байгаа албан тушаалтнуудад хаягт дахин өөрчлөлт оруулж нууц код олгуулах боломж байгаа эсэх талаар зөвлөгөө өгнө үү.

Сургуулиудын менежерүүд болох ТҮБД-6 шатлалаар цалинжиж байгаа албан тушаалтныг ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтаас хасах саналтай байна.

Цаашид ХАСХОМ гаргах албан тушаалтнуудад сургалт явуулж, сумдын Эрх бүхий албан тушаалтнуудын ажлын явц үр дүнд анхааран ажиллах болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН:



П.ЦЭЦЭГСҮРЭН

ХЯНАСАН:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Ц.ДАВААХҮҮ